



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/20/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.ov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт
Утас: 261628 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261628 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитор: М.Пагамдулам
Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.4.1 Мөнгөн хөрөнгө	13
3.4.2 Авлага.....	14
3.4.3 Урьдчилгаа	15
3.4.4 Бараа материал.....	15
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө	17
3.4.6 Үндсэн хөрөнгө.....	17
3.4.7 Өр төлбөр.....	18
3.4.8 Засгийн газрын хувь оролцоо	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт	19
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	19
4. Аудитын тайлан	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	22
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.5.1 Завсрын аудитын талаар.....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	23
5. Аудитын илрүүлэлт.....	24
5.1 Албан шаардлага	24
5.2 Зөвлөмж	25
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	27

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨЗГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023.03.24 № 01/658

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2/5-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Олон улсад хэрэгжиж буй "Green zone" төсөл нь дэлхийн 3 орны хотуудад амжилттай хэрэгжиж, камерын хяналтаар гэмт хэргийн 45.0-47.0 хувийг илрүүлсэн тэргүүн туршлага байгааг үндэслэн дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, "Аюулгүй хот"-ыг бий болгох зорилгоор "Ногоон бүс" төслийг хүрээнд халаасны хулгайн гэмт хэргийн 31.7 хувь үйлдэгддэг, Улаанбаатар хотын иргэдийн 60.0 орчим хувь нь зорчин өнгөрдөг, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, нэгдүгээр дөчин мянгатын нутаг дэвсгэрийг сонгон 61 цэгт, 145 теле хяналтын камерыг байршуулсан байна.

Мөн Нийслэл хотын нутаг дэвсгэрт үйлдэгдэж байгаа хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор цахим бугуйн гав "Burglar.police.gov.mn" цахим санд шинээр 1,792 хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн мэдээллийг оруулж, "ХУР" нэгдсэн сантай холбож, үйл ажиллагаандаа ашигласнаар хулгайн гэмт хэргийн илрүүлэлт өмнөх оноос 8.0 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Байцаан шийтгэх ажиллагааны зардалд улсын төсвөөс 2017-2022 онд нийт 3,542.7 сая төгрөг олгоод эргэн төлөгдсөн 69.6 сая, төлүүлэх шийдвэр гарсан ч төлөгдөөгүй 173.6 сая, хэрэг хэрэгсэхгүй болсон 41.7 сая, шийдвэрлэгдээгүй 3,247.8 сая төгрөг байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол тамга ТӨҮГ-ыг Засгийн газрын 2018 оны 9 дүгээр тогтоолоор татан буулгах шийдвэр гарч үйл ажиллагаа нь зогссон ч өглөг, авлагын тооцоог бүрэн шийдвэрлээгүй шалтгаанаар хаалтын баланс гараагүй, Цагдаагийн ерөнхий газрын тайланд нэгтгэгдэж байна.

Бусад мэдээлэл

Цагдаа дотоодын цэргийн албан тушаалын цалингийн сүлжээг Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 9-ны өдрийн 452 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоож, үндсэн цалинг 28.8-62.0 хувиар нэмэгдүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	70,784,443.9	98,675,042.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,407,422.5	13,350,659.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	347,250.4	228,465.3
34	УРЬДЧИЛГАА	16,393,664.4	26,873,940.4
35	БАРАА МАТЕРИАЛ	48,921,707.5	51,438,608.3
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	2,714,399.2	6,783,369.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	231,858,796.5	235,749,007.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	231,858,796.5	235,749,007.6
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	213,734,776.3	216,662,000.4
39300	Биет бус хөрөнгө	18,124,020.2	19,087,007.2
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	302,643,240.4	334,424,050.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,181,536.1	12,249,188.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,181,536.1	12,249,188.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	0.0	0.0
41300	Өглөг	4,465,850.4	195,475.8
41400	Урьдчилж орсон орлого	1,715,685.7	12,053,712.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	296,461,704.3	322,174,861.4
51	Засгийн газрын хувь оролцоо	296,461,704.3	322,174,861.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	84,065,917.3	84,507,689.4
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	84,065,917.3	84,507,689.4
51200	Хуримтлагдсан үр дүн	155,901,589.7	182,172,154.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,494,197.4	55,495,017.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	302,643,240.4	334,424,050.1

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	328,844,913.7	332,162,416.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,278,520.9	27,028,948.2
120	Нийтлэг татварын бус орлого	58,908,953.7	26,630,139.6
122	Тусламжийн орлого	369,567.2	398,808.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,566,392.8	305,133,468.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	276,893,808.3	300,463,846.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,893,808.3	300,463,846.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,726,819.8	267,275,549.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,732,363.7	182,755,463.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,119,325.1	4,507,126.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,561,844.6	5,912,518.7
2104	Хангамж, бараа материалын зардал	12,946,824.0	13,289,097.1
2105	Нормативт зардал	11,005,019.7	12,186,088.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,691,143.5	4,139,173.1
2107	Томилолт, зочны зардал	551,868.0	1,229,563.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,893,324.4	17,451,306.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,225,106.8	25,805,212.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,166,988.6	33,188,296.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	51,951,105.4	31,698,570.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	730.1	919.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,190,026.0	6,442,991.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	17,761,809.5	25,256,498.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,819,120.9	277,819,120.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	524,381.2	524,381.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	278,343,502.1	278,343,502.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(394,431.0)	(394,431.0)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	750,823.7	750,823.7
9	Тайлант үеийн үр дүн	17,761,809.5	17,761,809.5
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,461,704.3	296,461,704.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,014,066.1	1,014,066.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,475,770.4	297,475,770.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(999,179.5)	(999,179.5)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	441,772.1	441,772.1
19	Тайлант үеийн үр дүн	25,256,498.4	25,256,498.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	322,174,861.4	322,174,861.4

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12 дугаар сарын 31	2022 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	285,177,460.6	332,109,244.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,493,947.0	26,311,991.2
120	Нийтлэг татварын бус орлого	15,493,947.0	26,311,991.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	269,683,513.6	305,797,253.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	276,484,952.3	295,350,011.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	276,484,952.3	295,350,011.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	252,746,645.0	261,695,688.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,041,518.5	181,787,292.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,112,102.6	4,545,476.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,679,116.7	5,901,229.8
2104	Хангамж, бараа материалын зардал	9,906,078.9	11,182,363.3
2105	Нормативт зардал	13,513,513.6	13,994,584.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,810,002.6	8,947,978.5
2107	Томилолт, зочны зардал	629,418.1	1,174,804.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,861,752.6	30,283,836.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,193,141.2	3,878,122.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,738,307.4	33,654,322.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,692,508.3	36,759,233.4
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.0	0.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,032,360.6	25,863,630.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,032,360.6	25,863,630.8
2200	Дотоод эх үүсвэрээр	15,032,360.6	25,863,630.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(15,032,360.6)	(25,863,630.8)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(20,367.6)	47,634.2
14	Бусад эх үүсвэр	21,900.0	47,634.2
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	42,267.6	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(6,360,219.9)	10,943,236.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,767,642.4	2,407,422.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,407,422.5	13,350,659.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,457,019,500.00	285,027,510,468.40	429,509,031.60	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	274,923,986,500.00	274,494,477,691.40	429,508,808.60	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,226,096,000.00	250,866,348,565.19	359,747,434.81	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,596,707,300.00	174,510,616,766.64	86,090,533.36	100.0
210101	Үндсэн цалин	96,638,594,400.00	95,854,095,330.01	784,499,069.99	99.2
210102	Нэмэгдэл	70,200,891,300.00	68,476,226,456.34	1,724,664,843.66	97.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,048,423,100.00	1,323,839,210.59	(275,416,110.59)	126.3
210104	Урамшуулал	1,834,620,100.00	3,742,304,358.51	(1,907,684,258.51)	204.0
210105	Гэрээт ажлын хөлс	4,874,178,400.00	5,114,151,411.19	(239,973,011.19)	104.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,167,158,500.00	4,141,064,942.46	26,093,557.54	99.4
210201	Тэтгэрийн даатгал	-	25,951,958.23	(25,951,958.23)	
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,811,604.34	(1,811,604.34)	
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,449,285.80	(1,449,285.80)	
210204	Ажилгүйдлийн даатгал	-	344,406.01	(344,406.01)	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,167,158,500.00	4,111,507,688.08	55,650,811.92	98.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,893,928,400.00	5,843,235,145.13	50,693,254.87	99.1
210301	Гэрэл, цахилгаан	2,103,930,300.00	2,079,043,348.22	24,886,951.78	98.8
210302	Түлш, халаалт	3,161,936,400.00	3,132,837,984.91	29,098,415.09	99.1
210303	Цэвэр, бохир ус	553,460,900.00	557,974,741.00	(4,513,841.00)	100.8
210304	Байрны түрээс	74,600,800.00	73,379,071.00	1,221,729.00	98.4
2104	Хангамж, бараа материалын зардал	10,299,721,900.00	10,297,290,109.04	2,431,790.96	100.0
210401	Бичиг хэрэг	1,552,810,100.00	1,534,503,594.00	18,306,506.00	98.8
210402	Тээвэр, шатахуун	7,420,066,500.00	7,437,048,039.92	(16,981,539.92)	100.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	639,213,900.00	640,178,111.12	(964,211.12)	100.2
210404	Ном, хэвлэл	106,000.00	106,000.00	-	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,945,400.00	32,024,217.00	1,921,183.00	94.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	653,580,000.00	653,430,147.00	149,853.00	100.0
2105	Нормативд зардал	13,176,513,100.00	13,167,552,865.20	8,960,234.80	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,965,100.00	84,771,581.00	193,519.00	99.8
210502	Хоол, хүнс	2,229,308,600.00	2,221,871,639.20	7,436,960.80	99.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,862,239,400.00	10,860,909,645.00	1,329,755.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,994,714,500.00	7,991,499,195.46	3,215,304.54	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,636,981,300.00	3,634,674,154.00	2,307,146.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	229,722,400.00	229,575,873.00	146,527.00	99.9
210604	Урсгал засвар	4,128,010,800.00	4,127,249,168.46	761,631.54	100.0

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2107	Томилолт, зочны зардал	814,904,000.00	811,002,739.00	3,901,261.00	99.5
210702	Дотоод албан томилолт	814,904,000.00	811,002,739.00	3,901,261.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,377,665,900.00	32,204,075,455.79	173,590,444.21	99.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,713,134,700.00	31,544,162,509.84	168,972,190.16	99.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,306,400.00	2,306,400.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	407,933,500.00	407,933,430.95	69.05	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	92,989,300.00	90,751,358.00	2,237,942.00	97.6
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	26,158,700.00	24,833,700.00	1,325,000.00	94.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,349,500.00	34,345,210.00	4,290.00	100.0
210807	Газрын төлбөр	100,793,800.00	99,742,847.00	1,050,953.00	99.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,904,782,400.00	1,900,011,346.47	4,771,053.53	99.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,516,573,600.00	1,516,538,907.47	34,692.53	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	388,208,800.00	383,472,439.00	4,736,361.00	98.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,697,890,500.00	23,628,129,126.21	69,761,373.79	99.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	79,642,900.00	79,642,889.80	10.20	100.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	79,642,900.00	79,642,889.80	10.20	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,618,247,600.00	23,548,486,236.41	69,761,363.59	99.7
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	726,117,300.00	680,465,818.00	45,651,482.00	93.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	853,992,900.00	853,992,891.41	8.59	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,071,913,300.00	19,071,913,300.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,318,641,700.00	2,318,641,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	647,582,400.00	623,472,527.00	24,109,873.00	96.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,533,033,000.00	10,533,032,777.00	223.00	100.0
220001	Барилга байгууламж	10,225,687,300.00	10,225,687,135.00	165.00	100.0
221001	Их засвар	227,385,700.00	227,385,642.00	58.00	100.0
222001	Тоног төхөөрөмж	79,960,000.00	79,960,000.00	-	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,457,019,500.00	285,405,958,967.75	51,060,532.25	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	274,186,724,800.00	272,591,170,468.40	1,595,554,331.60	99.4
310001	Улсын төсвөөс санхүүжих	274,186,724,800.00	272,591,170,468.40	1,595,554,331.60	99.4
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,495,000.00	285,144,500.00	(32,649,500.00)	112.9
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	252,495,000.00	285,144,500.00	(32,649,500.00)	112.9

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,017,799,700.00	12,529,643,999.35	(1,511,844,299.35)	113.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,017,799,700.00	12,529,643,999.35	(1,511,844,299.35)	113.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	350,000.00	(350,000.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	350,000.00	(350,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	23,247	21,583	1,664.00	92.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	55	55	-	100.0
610001	Төсвийн байгууллага	55	55	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	11,596	10,764	832	92.8
620001	Удирдах ажилтан	181	168	13	92.8
620002	Гүйцэтгэх ажилтан	10,346	9,526	820	92.1
620003	Үйлчлэх ажилтан	448	455	(7)	101.6
620004	Гэрээт ажилтан	621	615	6	99.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		27,093,829,511.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ		21,285,690,253.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		15,518,770,319.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		7,253,704,357.42
210101	Үндсэн цалин		4,032,142,358.42
210102	Нэмэгдэл		144,694,002.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		290,000.00
210104	Урамшуулал		2,197,131,826.00
210105	Гэрээт ажлын хөлс		879,446,171.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		402,595,495.85
210201	Тэтгэврийн даатгал		47,793,076.70
210202	Тэтгэмжийн даатгал		268,720.13
210203	ҮОМШӨ-ний даатгал		214,975.70
210204	Ажилгүйдлийн даатгал		24,114.12
210205	Эрүүл мэндийн даатгал		354,294,609.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		57,994,617.00
210301	Гэрэл, цахилгаан		18,151,162.00
210302	Түлш, халаалт		31,734,365.00
210303	Цэвэр, бохир ус		8,109,090.00
2104	Хангамж, бараа материалын зардал		878,563,842.82
210401	Бичиг хэрэг		95,673,500.00
210402	Тээвэр, шатахуун		559,641,496.88
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		101,967,715.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		121,281,130.00
2105	Нормативт зардал		825,321,873.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		23,617,500.00

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

210502	Хоол, хүнс		481,653,275.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		320,051,098.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		2,580,729,082.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,881,069,214.00
210602	Тавилга		70,242,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		30,707,000.00
210604	Урсгал засвар		598,710,168.00
2107	Томилолт, зочны зардал		363,802,173.00
210701	Гадаад албан томилолт		149,172,400.00
210702	Дотоод албан томилолт		214,629,773.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,539,237,423.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,534,837,423.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		4,400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,616,821,455.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,232,256,035.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		384,565,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,766,919,933.81
2132	Бусад урсгал шилжүүлэг		4,754,169,718.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		50,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		4,754,119,718.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,012,750,215.81
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,012,750,215.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		5,808,139,258.00
2200	Дотоод эх үүсвэрээр		5,808,139,258.00
220001	Барилга байгууламж		3,433,721,834.00
222001	Тоног төхөөрөмж		1,779,465,000.00
223001	Бусад хөрөнгө		594,952,424.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		27,093,829,511.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		27,093,829,511.39
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		436,615,299.87
131103	ЗГНХ, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,065,683,244.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,540,586,533.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		21,050,944,434.52
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		1,543,572,019.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагдаагийн ерөнхий газар нь "Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болох" гэсэн алсын хараа, "Хуулийг дээдлэн хүний эрхийг хамгаалж, амар тайван амьдралын баталгааг хангах эрхэм зорилгын дор нэгдэж, үйл ажиллагааны чиглэл, зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Монгол цагдааг өв тэгш хөгжүүлэн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, албаны чадамжийг дээшлүүлэх;
- Цагдаагийн албаны бодлого, төлөвлөлт, зохицуулалтын чанарыг дээшлүүлж, байгууллагын чадавхыг сайжруулах;
- Үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангаж, үр дүнг нэмэгдүүлэх;
- Өндөр хурдтай мэдээллийн технологийг нэвтрүүлэх, цагдаагийн инновацын дэд бүтцийг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны баталгаатай, найдвартай байдлыг хангах;

Иргэдийн оролцоо бүх талын хамтын ажиллагааг дэмжихээр нийт 5 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 98.8 хувийн биелэлттэй үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлыг зохион байгуулах /код 141/ журам";
- Сангийн сайдын 2022 оны "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 120 дугаар тушаал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны "Журам батлах тухай-Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам" 65 дугаар тогтоол;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцлаа. Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь 2022 онд харьяа байгууллага, хэлтсүүдийн үйл ажиллагаанд төлөвлөсөн 10, төлөвлөгөөт бус 9 нийт 19 сэдвээр аудитыг төлөвлөн гүйцэтгэж, 75 зөвлөмж өгсөн байна. Үүнээс санхүү, нягтлан бодох бүртгэл, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр 4 хяналтыг гүйцэтгэж, 12 зөвлөмж өгч, нийт хэрэгжилтийг 100 хувийн биелэлттэй, үнэлж тайлагнасан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил, гүйлгээг аккрузел сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Цагдаагийн байгууллагуудад мөрдөж байгаа НБББББ-ийг Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалаар анх баталж, 2015 оны А/118, 2016 оны Б/344 дүгээр тушаалаар тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус бодлогын баримт бичигт тусгасан дансны нэгдсэн жагсаалтыг санхүүгийн программтай уялдуулан шинэчлэх, холбогдох заавар, журмуудыг одоо байгаа заавар, журмуудаар шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,780.8 сая төгрөгөөр буюу 10.5 хувиар нэмэгдсэн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 13,350.7 сая төгрөг болж, өмнөх оноос 10,943.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/ сая төгрөг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	0.4	0.4	-
Банканд байгаа бэлэн мөнгө	2,407.1	13,350.3	10,943.2
Төгрөг	2,407.1	4,131.4	1,724.3
Төрийн сангийн харилцах	2,407.1	4,088.2	1,681.1
Арилжааны банк дахь харилцах	0.0	43.2	43.2
Гадаад валют	-	9,218.9	9,218.9
Төрийн сангийн харилцах	-	9,218.9	9,218.9
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Дүн	2,407.4	13,350.7	10,943.2

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 0.4 сая төгрөг нь касс, Төрийн сангийн төгрөгийн харилцахад хөрөнгө оруулалтын ажлын барьцаа 2,522.6 сая, техник хяналтын 239.4 сая, ахмадын сангийн 1,326.2 сая, бусад 5.9 сая, Төрийн сангийн валютын дансанд Эрүүгийн цагдаагийн албаны эрүүгийн хэргээс хураан авсан мөнгөний барьцаа 9,218.9 сая, Худалдаа хөгжлийн банкны харилцах дансанд Монгол тамга ТӨҮГ-ын авлагын барагдалт 43.2 сая төгрөг байршиж байна.

Аудитын илрүүлэлт:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

- Цалингийн зардлын хэмнэлтээс 99.3 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн. /Сүүж-Уул нөхөн сэргээх сувилал 8.7 сая, Экологийн цагдаагийн алба 7.8 сая, Дотоодын цэргийн 05 дугаар анги 32.4 сая, Дотоодын цэргийн 805 дугаар анги 20.3 сая, Төмөр зам дахь цагдаагийн газар 7.4 сая, Хүч спорт хороо 2.5 сая, Эрүүгийн цагдаагийн алба 3.5 сая, Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар 11.0 сая, Дотоодын цэргийн штаб 6.1 сая, Сүлд чуулга 10.6 сая /;
- Ахмадын санд цалингийн сангийн 3 хувиас 47.7 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн. /Санхүү, аж ахуйн алба 47.7 сая/;
- Санхүү, аж ахуйн алба 154.6 сая төгрөгийн техник хяналтын зардлын хэмнэлтийг төсөвт төвлөрүүлээгүй;
- И-баримтаар баталгаажуулаагүй бараа, ажил, үйлчилгээний 113.6 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Баянхонгор аймгийн Цагдаагийн газар 1.5 сая, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар 18.0 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс 2.4 сая, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэсэг 5.2 сая, Баянгол дүүргийн цагдаагийн газар 69.2 сая, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар 6.5 сая, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар 10.8 сая/;
- Харьцуулалтын аргаас залсхийж, хэсэгчлэн хувааж 141.3 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. /Санхүү, аж ахуйн алба 72.9 сая, Дотоодын цэргийн штаб 68.4 сая/;
- Төсвөөс 111.8 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. /Орхон аймгийн Цагдаагийн газар 0.5 сая, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар 1.8 сая, Захиргааны удирдлагын газар 82.8 сая, Экологийн цагдаагийн алба 2.3 сая, Хүч спорт хороо 1.0 сая, Тээврийн цагдаагийн алба 13.8 сая, Нийслэлийн цагдаагийн удирдах газар 9.5 сая/;
- Санхүү, аж ахуйн алба тухайн үеийн удирдах албан тушаалтны буруу шийдвэрээс шалтгаалан төсвөөс 60.6 сая төгрөгийн нөхөн олговор олгосон;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 73.9 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс 23.6 сая, Булган аймгийн Цагдаагийн газар 3.3 сая, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар 4.1 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс 7.6 сая, Экологийн цагдаагийн алба 8.5 сая, Баянгол дүүргийн цагдаагийн газар 23.6 сая, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар 0,6 сая, Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар 2.6 сая/.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 228.5 сая төгрөг болж, өмнөх оноос 118.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	4.0	10.3	6.3
Төлбөртэй үйлчилгээний авлага	44.0	1.8	(42.3)
Татаас, санхүүжилтийн авлага	14.0	28.4	14.4
Дансны авлага /ТӨҮГ/	80.6	33.0	(47.6)
Байгууллагаас авах авлага	127.4	29.7	(97.7)
Хувь хүмүүсээс авах авлага	77.2	125.4	48.1
Дүн	347.3	228.5	(118.8)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Монгол тамга ТӨҮГ-ын 80.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 47.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 33.0 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагын үлдэгдэл байна.

Хувь хүнээс авах авлагад Санхүү, аж ахуйн албаны жилийн эцсийн тооллогоор байгууллагын малчны мал дутагдуулсны төлбөр 35.4 сая, бусад хүмүүсээс авах 2.1 сая, Хэнтий аймгийн Цагдаагийн газрын орон сууцны тооцооны 69.2 сая, Баянхонгор аймгийн Цагдаагийн газрын

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

байгууллагын мал борлуулсны 14.7 сая, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Сум дундын цагдаагийн хэлтсийн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 3.7 сая, Булган аймгийн Цагдаагийн газрын 0.2 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Жилийн эцэст 4.2 сая төгрөгийн авлагыг үлдэгдлийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /Булган аймгийн Цагдаагийн газар 0.4 сая, Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс 1.4 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын цагдаагийн хэлтэс 0.4 сая, Ховд аймгийн Цагдаагийн газар 2.0 сая/

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 26,873.9 сая төгрөг болж, өмнөх оноос 10,480.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	3,110.9	1,920.7	(1,190.2)
Урьдчилгаа тооцоо	13,282.8	24,953.2	11,670.5
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	4,145.7	4,044.6	(101.1)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9,136.4	20,908.1	11,771.8
Цалингийн урьдчилгаа	0.7	0.5	(0.2)
Дүн	16,393.7	26,873.9	10,480.3

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд Санхүү, аж ахуйн албаны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийн урьдчилгаа 642.1 сая, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын судалгаа шинжилгээ хийлгэх 128.0 сая, Ховд аймгийн Цагдаагийн газрын барилгын зураг төсвийн үнэ болон сургалтын танхимын засварын 97.7 сая, бусад урсгал зардлын 1,052.9 сая төгрөгийн урьдчилгаа тус тус бүртгэлтэй байна.

Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын дүрэмт хувцас, дагалдах хэрэгсэл худалдан авах гэрээний 3,753.2 сая, сургалтын сум хэрэгсэл худалдан авах 226.3 сая, тусгай хэрэгсэл 59.3 сая, бусад 5.8 сая төгрөгийн бараа материал худалдан авалтын урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдэл байна.

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансанд морьт эргүүлийн адууны жүчээний цогцолбор барилгын санхүүжилтийн 1,345.9 сая, автомашин бэлтгэх 86.0 сая, санхүүгийн түрээсийн гэрээний төлбөрийн 19,421.5 сая, их засварын 54.7 сая төгрөгийн гэрээний урьдчилгаа төлбөрүүд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Цагдаа, дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын алба 239.5 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 51,438.6 сая төгрөг болж, өмнөх оноос 2,516.9 сая төгрөгөөр өссөн байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	13,748.2	16,564.7	2,816.5
Тусгай зориулалттай материал	13,495.3	16,286.5	2,791.2
Эм боох материал	253.0	278.2	25.3
Бэлэн бүтээгдэхүүн	6,282.0	6,525.4	243.4
Хангамжийн материал	27,994.3	27,372.1	(622.2)
Бичиг хэргийн материал	4,507.1	3,459.9	(1,047.2)
Аж ахуйн материал	2,251.4	2,289.2	37.8
Сэлбэг хэрэгсэл	230.2	247.1	16.9
Түлш, шатах тослох материал	1,656.9	1,309.2	(347.6)
Барилгын засварын материал	490.3	407.2	(83.1)
Хүнсний материал	372.1	664.4	292.3
Бусад хангамжийн материал	18,486.3	18,995.1	508.8
Мал амьтад	897.1	976.4	79.3
Дүн	48,921.7	51,438.6	2,516.9

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд бараа материал худалдан авсан 43,297.0 сая, хандив, тусламжаар үнэ төлбөргүй авсан 50.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 20,341.2 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 1,138.6 сая, үндсэн хөрөнгөнөөс бараа материалд шилжүүлсэн 3.6 сая, бараа материалын данс хооронд залруулсан 144.5 сая, малын нас дэвшилтээр 299.9 сая, хувцас болон хэвлэх үйлдвэрийн тооцоогоор 455.5 сая, нийт 65,731.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүнээс байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 30,788.0 сая, балансаас баланст шилжүүлсэн 29,944.0 сая, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлсэн 116.0 сая, бараа материалын данс хоорондын залруулга 144.5 сая, малын нас дэвшилтийн үнийн зөрүү 299.9 сая, акталсан 1,270.0 сая, бусад тооцооны 651.9 сая, нийт 63,214.3 сая төгрөгөөр хасагдсан байна. Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд тусгай зориулалтын материал худалдан авалт голлон нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалыг орлогод аваагүй, тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 26.5 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар 4.6 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын цагдаагийн хэлтэс 1.2 сая, Баянгол дүүргийн цагдаагийн газар 18.0 сая, Говь сүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс 2.7 сая/;
- Санхүү, аж ахуйн алба нь 12.0 сая төгрөгийн угаалгын нунтаг, ариутгагч, үнэр дарагч, хогны уут зэрэг он дамжсан бараа материалын үлдэгдэлтэй;
- Бараа материалын тайланд 61.3 сая төгрөгийн шатахуун болон хүнсний материалын хэмжих нэгж, нэг бүрийн үнийг буруу илэрхийлж бөөн дүнгээр бүртгэсэн. /Хан-Уул дүүргийн цагдаагийн газар 59.8 сая, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс 1.5 сая/;
- Санхүү, аж ахуйн алба түлш шатахууны үлдэгдлийг тооллогын бүртгэлээс 9.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Цагдаагийн ерөнхий газар 78.9 сая төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн;
- Төсвөөс 3.3 сая төгрөгөөр биеийн тамирын болон бэлтгэлийн хувцас худалдаж авсан. /Өмнөговь аймгийн Цагдаагийн газар 0.6 сая, Сүлд чуулаа төсвөөс 2.7 сая/;
- Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар 1.7 сая төгрөгийн бараа материалыг буруу ангилан бүртгэсэн.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 6,783.4 сая төгрөг болж, өмнөх оноос 4,069.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	2,714.3	6,783.4	4,069.1
Дүн	2,714.3	6,783.4	4,069.1

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэлд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр хуримтлуулан бүртгэсэн 6,783.4 сая төгрөгийн дуусаагүй ажил бүртгэлтэй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 225,749.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,109.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл */сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	213,734.8	216,662.0	2,927.2
Барилга, байгууламж, орон сууц	145,995.2	148,453.6	2,458.4
Авто-тээврийн хэрэгсэл	21,130.0	18,788.9	(2,341.1)
Машин, тоног төхөөрөмж(компьютер)	28,792.9	29,380.8	587.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,979.6	4,985.4	5.8
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,646.6	4,742.8	96.2
Бусад үндсэн хөрөнгө	8,136.9	10,310.5	2,173.6
Дуусаагүй барилга, байгууламж	53.7	-	(53.7)
Биет бус хөрөнгө	18,124.0	9,087.0	(9,037.0)
Программ хангамж	891.7	979.0	87.3
Бусад биет бус хөрөнгө	17,232.3	8,108.0	(9,124.3)
Дүн	231,858.8	225,749.0	(6,109.8)

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 5,382.6 сая, хандиваар хүлээн авсан 347.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 16,662.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 6,972.3 сая, бараа материалаас шилжүүлэн авсан 116.0 сая, үндсэн хөрөнгийн ангилал хооронд шилжүүлсэн 60.9 сая, урьдчилж төлсөн зардлаас хөрөнгөд орлого авсан 1,254.7 сая, газар эзэмших эрхийг бүртгэсэн 1,007.1 сая, нийт 9,411.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр акталсан 3,616.3 сая, балансаас баланст шилжүүлсэн 3,499.6 сая, үндсэн хөрөнгөөс бараа материалын дансанд шилжүүлсэн 9.5 сая, үнэ шинэчлэн тогтоохоор данснаас хассан 9,815.1 сая, бусад 56.5 сая, нийт 10,507.3 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд 6.0 сая төгрөгийн хангамжийн материал бүртгэсэн. /Архангай аймгийн Цагдаагийн газар 3.2 сая, Сүлд чуулаа 1.6 сая, Сонгино хайрхан дүүргийн Цагдаагийн газар 1.2 сая/;
- Цагдаа, дотоодын цэргийн алба гэрээнд заасан үнээс 23.0 сая төгрөгөөр илүү үнээр хөрөнгө бэлтгэсэн;
- Сонгино хайрхан дүүргийн Цагдаагийн газар 27.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг буруу тооцоолж бүртгэсэн;
- Цагдаагийн ерөнхий газар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй 78.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12,253.0 сая төгрөг болж, өмнөх оноос 6,053.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өглөг	66.6		(66.6)
Байгууллагад төлөх өглөг	4,342.0	128.4	(4,213.6)
Хувь хүмүүст төлөх өглөг	0.3	0.3	0.0
Татварын өглөг /ТӨҮГ/	51.6	51.6	(0.0)
Дансны өглөг /ТӨҮГ/	5.4	1.0	(4.4)
Урьдчилж орсон орлого	1,715.7	12,053.7	10,338.0
Дүн	6,181.5	12,235.0	6,053.5

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Байгууллагад төлөх өглөгийн дансанд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын автомашины парк шинэчлэлтэй холбоотой үүссэн 4,213.6 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэлд Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах албаны эрүүгийн хэргийн барьцаа 10,138.1 сая, Санхүү, аж ахуйн алба, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгө 1,532.0 сая төгрөг бүртгэлтэй байна. Мөн Монгол Тамга ТӨҮГ-ын 51.6 сая төгрөгийн татварын он дамжсан өглөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Жилийн эцэст 2.3 сая төгрөгийн өглөг, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй. /Дорнод аймгийн Цагдаагийн газар 1.6 сая, Булган аймгийн Цагдаагийн газар 0.3 сая, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Сум дундын цагдаагийн хэлтэс 0.4 сая/;
- Цагдаа, дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын алба 354.3 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 322,174.9 сая төгрөг болж, өмнөх оноос 25,713.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	84,065.9	84,507.7	441.8
Өмч /терийн/ /ТӨҮГ/	84,065.9	84,507.7	441.8

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			-
Хуримтлагдсан үр дүн	155,901.6	182,172.2	26,270.6
Өмнөх үеийн үр дүн	138,139.8	156,915.7	18,775.9
Тайлант үеийн үр дүн	17,761.8	25,256.5	7,494.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,494.2	55,495.0	(999.2)
Дүн	296,461.7	322,174.9	25,713.2

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 441.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь харьяа 14 байгууллага газар эзэмших эрхийг орлогоод авсан, шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 55,495.0 сая төгрөг болж, 999.2 сая төгрөгөөр буурсан нь харьяа 19 байгууллагын акталсан болон данс бүртгэлээс хасаж дахин үнэлсэн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хасаж бүртгэсэнтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 182,172.2 сая төгрөг болж, 26,270.6 сая төгрөгөөр өссөн нь харьяа 18 байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн залруулга 18,775.9 сая төгрөг болон тайлант үеийн үр дүн 25,256.5 сая төгрөг байгаа нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд нийт зарлага 688,519.3 сая төгрөгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 674,722.5 сая, үйл ажиллагааны орлогоос 13,544.3 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 252.5 сая төгрөг бүрдүүлэхээр боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс урсгал зардлыг 167,470.1 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 232,032.7 сая, нийт 399,502.8 сая төгрөгөөр бууруулж, 289,016.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ыг баримтлан 5751 орон тоог нэмэх санал боловсруулан төлөвлөсөнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийг 2 удаа тодотгож, тодотголоор 3,560.2 сая төгрөгөөр бууруулж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 11 арга хэмжээнд зориулж 285,456.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр улсын төсвөөс урсгал зардалд 263,653.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 10,533.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 252.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоор 11,017.8 сая төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс урсгал зардалд 262,057.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 10,533.0 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 252.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоор 11,017.8 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 285,027.5 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 429,508.8 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээнд 10,533.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 9,281.4 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлээр олгож, 1,251.6 сая төгрөгийг барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
Код	Нэр				
Нийт дүн		285,457,019.5	285,027,510.5	(429,509.0)	99.8
70704	Цагдаа	278,819,894.9	278,402,588.9	(417,306.0)	99.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	226,862,306.2	226,682,771.7	(179,534.5)	99.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	22,764,254.7	22,694,493.3	(69,761.4)	99.7
82315	Байцаан шийтгэх ажиллагаа	789,686.2	705,777.0	(83,909.2)	89.4
81822	Гадаад суралцагсдын зардал	853,992.9	853,992.9	(0.0)	100.0
80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	79,642.9	79,642.9	(0.0)	100.0
82201	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	84,484.2	84,484.2	-	100.0
82324	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	1,266,716.9	1,266,716.9	-	100.0
80220	Холбооны суваг ашигласны хөлс	85,777.9	85,777.9	-	100.0
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	15,500,000.0	15,415,899.3	(84,100.7)	99.5
80918	Бусад /Хөрөнгө оруулалт/	10,533,033.0	10,533,032.8	(0.2)	100.0
70711	Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах	6,637,124.6	6,624,921.6	(12,203.0)	99.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,637,124.6	6,624,921.6	(12,203.0)	99.8

Төсвийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 1,559.0 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 378.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив, тусламжаар 436.6 сая, аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,065.7 сая, дээд шатны төсвийн захирагчаас 4,540.6 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,050.9 сая, нийт 27,093.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 20,272.9 сая, хөрөнгийн зардалд 5,808.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,012.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитор С.Отгонхорлоо, М.Пагамдулам нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/165 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 275,637.0 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 2,756.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудад Цагдаагийн ерөнхий газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 01/336 дугаар албан бичгээр төсвийг 1,969.9 сая төгрөгөөр бууруулж баталсантай холбоотой хэмнэлтийн горимд шилжиж, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах талаар 10 заалт бүхий чиглэл өгч, биелэлтийг тооцож ажилласан байна. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуульд зааснаас өөр тэргүүн дэд, дэд даргыг ажлаас чөлөөлж, цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн 21 алба хаагчийг цэргийн алба хаасны болон өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлсөн, баталсан орон тооноос 832 алба хаагчаар дутуу ажиллаж, цалин, НДШ-ийн зардлыг 112.1 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Цагдаагийн алба үйлчилгээнд ажиллаж байсан туулах чадвар өндөртэй 5 автомашиныг татан төвлөрүүлж, шаардлагатай тохиолдолд удирдамж төлөвлөгөөний дагуу хөдөө орон нутагт ажиллуулж, авто баазад харьяа 66 нэгжийн 75 автомашиныг байршуулж, дуудлагын горимоор 86 автомашиныг ажиллуулсны үр дүнд 29.6 сая төгрөгийн шатахууныг хэмнэсэн;

- Гэмт хэрэгтэй тэмцэхээс бусад чиглэлээр хөдөө орон нутагт ажиллуулахыг бууруулж 3.9 сая төгрөгийн албан томилолтын зардлын хэмнэсэн;
- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын ажлын байрны сургалтыг Zoom программ ашиглан зохион байгуулж, давхардсан тоогоор 112 удаагийн сургалтад 15164 алба хаагчийг хамруулсан, төсвийн хөрөнгөөс ном, хэвлэл, бэлэг дурсгалын зүйл худалдан авах, уралдаан тэмцээн, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд 17 байгууллага 2,636.7 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй 46 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.1-д дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэгтэй албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/58 дугаар тушаалаар 2020 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс хойш хүүхэд асрах чөлөөг авсан алба хаагчид чөлөөтэй байх хугацаанд цэрэг, цагдаагийн цолны нэмэгдэл цалинг олгож байхаар шийдвэрлэсний дагуу 91 албан хаагчид 188,625.6 мянган төгрөгийн цолны нэмэгдэл олгосон байна. Энэ нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө цэргийн алба хаагчид цалин хөлс олгоно", 9.2-т "Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас гадна доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:....9.2.3-д онцгой нөхцөлийн" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэрэг, цагдаагийн цолтой эхчүүдэд хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд цэрэг, цагдаагийн цолны цалинг олгохдоо холбогдох эрх зүйн акттай нийцүүлж шийдвэрлэж байх зөвлөмж өгөв.

Харьяа байгууллагуудад илэрсэн нийцлийн аудитын асуудлаар нийт 79.4 сая төгрөгийн 7 зөрчил илрүүлснээс 57.6 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 21.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд мэдээлэл дутуу байршуулсан зөрчил давтагдаж гарсан тул Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагдаагийн Ерөнхий газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 17 төсвийн шууд захирагчийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж, тус аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 229.7 сая төгрөгийн зөрчил арилгах 2 албан шаардлага, 1,087.0 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилтийн байдал дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	2	229.7	2	127.0	100.0
Зөвлөмж	2	1,087.0	-	-	0.0
Нийт	4	1,316.7	2	127.0	50.0

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдсан байна. Зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цагдаагийн ерөнхий газар нь цагдаагийн авто баазад парк шинэчлэл хийх зорилгоор хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй 2018 онд 1,350.0 сая төгрөгийн үндсэн төлбөртэй, 4.5 хувийн хүүтэй, 2021 онд 34,580.1 сая төгрөгийн төлбөртэй санхүүгийн түрээсийн гэрээг тус тус байгуулсан байна. Санхүүгийн түрээсийн гэрээнд зааснаар түрээсийн төлбөрийг 5-10 жилийн хугацаанд бүрэн төлсний дараа хөрөнгийг өмчлөлд шилжүүлэхээр байна. Иймээс бэлтгэсэн автомашинуудын бүртгэл, ашиглалт, гэрээний хэрэгжилт, үр дүнг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 737.2 сая төгрөгийн 36 алдаа¹ илэрснээс аудитын явцад 676.9 сая төгрөгийн 24 алдааг залруулж, 60.3 сая төгрөгийн 12 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Үүнд: Санхүүгийн тайланд мэдээлэл тусгалгүй орхигдуулсан 259.3 сая, нягтлан бодох бүртгэл болон тайлагналтай холбоотой 538.2 сая төгрөгийн алдаа илэрсэн.

Аудитаар нийт 1,960.8 сая төгрөгийн 115 зөрчил² илэрснээс, 4.1 сая төгрөгийн 5 төлбөрийн акт тогтоож, 589.5 сая төгрөгийн 25 албан шаардлага хүргүүлж, 1,555.8 сая төгрөгийн 85 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 54 төсвийн байгууллага, 1 төрийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан нийт 55 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллага гүйцэтгэх ажиллагааны, 18 байгууллага түүвэрт хамруулж, 36 байгууллагад дүгнэлт гаргасан. Аудитад хамрагдсан 36 харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч

5.1 Албан шаардлага

1. Цагдаагийн ерөнхий газар харьцуулалтын аргаас залхийж харьяа 9 байгууллагаас нэг аж ахуйн нэгж байгууллагатай шууд худалдан авах гэрээ байгуулж 78.9 сая төгрөгийн бараа материалын нөөц үүсгэсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалт, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 8.7.1-т "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагагүй бараа материалын нөөц үүсгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Цагдаагийн ерөнхий газар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн төсвөөс бэлтгэхээр төлөвлөсөн автомашины үнийн зөрүү 30.0 сая төгрөгийг Санхүү, аж ахуйн газрын урсгал зардлаас, Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангиуд худалдан авах төлөвлөгөөнд тусгаагүй 40 тн-ийн 2 ш зөөврийн хөлдөөгчийг нэг аж ахуйн нэгжтэй тус тус шууд гэрээ байгуулж, урсгал зардлаас 48.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан Босго үнэ шинэлэн батлах тухай ТӨБОНӨХБАҮ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн 3-д "Харьцуулалтын аргаар ажил, үйлчилгээ гүйцэтгэх төсөвт өртгийн дээд хязгаар 70 сая төгрөг" гэсэн заалтуудыг зөрчсөн.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулах, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны урсгал зардлын төсвөөс автомашин, компьютер, техник хэрэгсэл бэлтгэж, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" Үүнд: 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өссөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн төлөвлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Эрдэнэс таван толгой ХК-аас харуул хамгаалалтын гэрээний дагуу олгох үйл ажиллагааны зардлын санхүүжилтийг Цагдаагийн ерөнхий газрын төсөвт төлөвлөөгүй, үндсэн үйл ажиллагааны орлого, зарлагаар хүлээн зөвшөөрч бүртгэхгүй, Цагдаа дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын албаны нэмэлт дансанд төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн, 4 дүгээр зүйлийн 4.1.9-д "төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг", 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчсөн.

1.2 Өгсөн зөвлөмж:

Гэрээт харуул хамгаалалтын ажил гүйцэтгэсний орлогыг төлөвлөж, төсвийн төлөвлөгөөнд тусгах, үндсэн үйл ажиллагааны орлогоор хүлээн зөвшөөрч, иж бүрэн тайлагнаж байх.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлантай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,541.1 сая төгрөгийн 146 алдаа, зөрчил илрүүлснээс 676.9 сая төгрөгийн 24 алдааг залруулж, 4.1 сая төгрөгийн төлбөрийн 5 акт тогтоож, 432.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлага хүргүүлж, 1,427.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 97 зөвлөмжийг хүргүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.5-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээний

агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийж, дотоод хяналтын үйл ажиллагаа, хариуцлагыг сайжруулах, өмнөх аудитаар Шилэн дансны хэрэгжилтээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцаж, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар төлөвлөгөө, удирдамж гаргаж, үе шаттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.